

БАТЛАВ:

"МОНГОЛРОСЦВЕТМЕТ" ТӨҮГ-ЫН
ЗАХИРАЛ



Д.ТОГТОХСҮРЭН

БАТЛАВ:

"МОНГОЛ НЬЮС" ХХК-ИЙН
ЕРӨНХИЙ ЗАХИРАЛ – 2



Б.НАНДИНТУШИГ

ХАМТЫН АЖИЛЛАГААНЫ ГЭРЭЭ

№ МР-2025-06-04

2025 оны 02 сарын 07 өдөр

Улаанбаатар хот

Нэг талаас "Монголросцветмет" ТӨҮГ /цаашид Захиалагч гэх/ түүнийг төлөөлж Санхүү, эдийн засгийн асуудал хариуцсан газрын дарга Н.Тэгшжаргал /Регистрийн дугаар 2550466/, нөгөө талаас "Монгол Ньюс" ХХК-ийн "Өнөөдөр" сонин хэвлэл мэдээллийн хэрэгсэл /цаашид Нийлүүлэгч гэх/ түүнийг төлөөлж олон нийттэй харилцах албаны менежер, сэтгүүлч Ю.Төгсжаргал /Регистрийн дугаар 209739/ нар /хамтад нь Талууд гэх/ харилцан тохиролцсоны үндсэн дээр энэхүү гэрээг дор дурдсан нөхцөлөөр байгуулав.

Нэг. Ерөнхий зүйл

1.1. Энэхүү гэрээгээр Нийлүүлэгч нь:

- Улс орны хөгжил, эдийн засаг, урлаг соёл, спортын болон хувь хүний аж амьдралд санаа авч амьдралдаа хэрэгжүүлж болохуйц мэдээ мэдээллийг, үнэн зөв, бодит, тэнцвэртэй, баттай эх сурвалжаас бэлтгэсэн мэдээллийг хэвлэн нийтэлсэн "Өнөөдөр" сониныг Захиалагчид захиалгын дагуу нийлүүлэх.

- "Өнөөдөр" сонинд Захиалагчийн зарласан ажлын зар, ажил гүйцэтгүүлэх урилга (залруулга)-ыг хэвлэн нийтлэх,

- Захиалагч нь:

- Өдөр тутмын сонины захиалгын төлбөр болон ажлын байрны зар, ажил гүйцэтгүүлэх урилгыг хэвлэн нийтэлсний төлбөрийг гэрээнд заасан нөхцөлийн дагуу төлөхтэй холбоотой харилцааг зохицуулна.

1.2. Энэхүү гэрээ нь Талууд гэрээнд гарын үсэг зурж, баталгаажуулан хүчин төгөлдөр болсон өдрөөс 2025 оны 12 дугаар сарын 31-ны өдрийг дуустал хугацаанд хүчинтэй байна.

Хоёр. Нийлүүлэгчийн эрх, үүрэг

2.1. Нийлүүлэгч нь "Өнөөдөр" сониныг Захиалагчийн албан хэрэгцээнд, түүний хүлээн авах хаягийн дагуу, захиалсан тоо хэмжээгээр цаг тухайд нь тогтмол саадгүй хүргэнэ.

Захиалагчийн салбарууд:

- Улаанбаатар хот, Энхтайвны өргөн чөлөө-98, "Монголросцветмет" ТӨҮГ-ын байр,
- Хэнтий аймаг, Бор-Өндөр сум, "Бор-Өндөр" Уулын баяжуулах үйлдвэр,
- Төв аймаг, Заамар сум, Өгөөмөр тосгон, "Шижир-Алт" Алтны үйлдвэр,

2.2. Захиалагчаас зарлаж буй төрөл бүрийн зарыг "Өнөөдөр" сонинд нийтлэхдээ зар тус бүрийг 50%-ийн хөнгөлөлттэй үнээр нийтэлнэ.

2.3. Нийлүүлэгч нь "Өнөөдөр" сониныг энэхүү гэрээний хавсралт №1-ээр баталсан хуваарийн дагуу захиалах бөгөөд хавсралт №1 нь энэхүү гэрээний салшгүй нэгэн хэсэг болно.

Гурав. Захиалагчийн эрх, үүрэг

3.1. Нийлүүлэгчээс “Өнөөдөр” сонин, захиалагчаас өгсөн зар, цаг үеийн мэдээ мэдээлэл, нийтлэл, ярилцлага зэргийг захиалгын дагуу, тогтоосон хугацаанд нийлүүлэх, хэвлэн нийтлэх, алдаа дутагдал гарсан тохиолдолд залруулахыг шаардах эрхтэй.

3.2. Захиалагч нь өөрийн салбар бүрийн хүлээн авах хэвлэлийн тоо, хаягийг улирал тутамд “Өнөөдөр” сонины ЗМЗБалбанд өгч захиалгын тооцоог нэхэмжлэхийн дагуу саадгүй шилжүүлэх үүрэгтэй.

Дөрөв. Төлбөр тооцоо, хугацаа

Тав. Бусад зүйл

5.1. Энэхүү гэрээ нь 2 тал баталгаажуулсан өдрөөс эхлэн хүчин төгөлдөр болж мөрдөгдөнө.

5.2. Талууд гэрээнд нэмэлт өөрчлөлт оруулж болох бөгөөд нэмэлт өөрчлөлт бүрийг бичгээр үйлдэнэ.

5.3. Талууд гэрээтэй холбоотой аливаа маргааныг харилцан зөвшилцөж шийдвэрлэхийг эрхэмлэх ба харилцан зөвшилцөж чадаагүй тохиолдолд Монголын Олон Улсын арбитраар шийдвэрлүүлнэ.

ГЭРЭЭ БАЙГУУЛСАН:

“МОНГОЛПРОСЦВЕТМЕТ” ТЭҮГ-ЫГ
ТӨЛӨӨЛЖ:
САНХҮҮ, ЭДИЙН ЗАСГИЙН
АСУУДАЛ ХАРИУЦСАН ГАЗРЫН ДАРГА

.....Н.ТЭГШЖАРГАЛ

ХАЯГ:
БАЯНЗҮРХ ДҮҮРЭГ, ЭНХТАЙВНЫ
ӨРГӨН ЧӨЛӨӨ-98
УТАС: 458-072, 458-380

“МОНГОЛ НЬЮС” ХХК-ИЙГ
ТӨЛӨӨЛЖ:
ОНХА-НЫ МЕНЕЖЕР, СЭТГҮҮЛЧ

.....Ю.ТӨГСЖАРГАЛ

ХАЯГ:
ЧД, ЖУУЛЧНЫ ГУДАМЖ-40
“МОНГОЛ НЬЮС” ХХК-ИЙН БАЙР
УТАС: 99153131